

БНЭУ-ЫН ГАДААД БОДЛОГЫН ХУВЬСАЛ, ИХ ГҮРНҮҮДИЙН ГЕОПОЛИТИКИЙН СОНИРХОЛ

*МУИС, ОУХС-ийн багш,
ГХЯ-ны зөвлөх
Д.Баярхүү*

Энэхүү өгүүллийг бичигч нь 1998-2001 онд Монгол улсаас БНЭУ-д суугаа Элчин сайдын Яаманд Зөвлөхөөр ажиллаж байсан бөгөөд Дели дэх нөр их ажлын хажуугаар гадаад бодлого-олон улсын харилцааны судалгааны ажлаа үргэлжлүүлж "Олон улсын харилцаа, геополитикийн сонирхол" ном монгол хэлээр, эрдэм шинжилгээний 4 товхимол, 8 өгүүлэл англи хэлээр хэвлүүлж тэдгээртээ Өмнөд Ази, Ази-Номхон далайн бүс нутгийг тойрсон улс төр-эдийн засгийн харилцаа, дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явц, глобалчлал, түүний эерэг ба сөрөг нөлөөлөл зэрэг тулгам чухал асуудлыг хөндөн бичиж Монгол, Энэтхэгийн судлаачид, уншигчдын хүртээл болгосон юм.

Урьд нь "шинэ тулгар хөгжиж буй", "эвсэлд нэгдээгүй", "гурав дахь ертөнцийн" зэрэг элдэв тодотголтой явсан Энэтхэг улс 1998 оны 5 дугаар сараас (цөмийн зэвсэгтэй болсноо албан ёсоор нотолсон) түүхийнхээ цоо шинэ үед шилжиж бүс нутгийн төдийгүй дэлхийн томхон гүрэн бэхлэлийн замдаа орсон билээ. Эдүгээ цөмийн зэвсэгтэй, хүчирхэгжиж буй армитай, мэдээллийн технологийн ба оюуны асар их потенциалтай, тэр хэрээрээ бүс нутгийн болон дэлхийн хэмжээний глобал асуудлаар дуу хоолой байр суурь нь илт үгүйлэгдэж буй Энэтхэгийн тухай ярьж бичих нь их болжээ. Энэ тухай зохиогч "Олон улсын харилцаа, геополитикийн сонирхол" номдоо дэлгэрэнгүй бичсэн байна.

Энэтхэг түүний эргэн тойрны бүс нутагт солбицож уулзах их гүрнүүдийн геополитикийн сонирхлын хувьсал, түүнийг даган дасан зохицсон БНЭУ-ын гадаад бодлогын хувьсал зэргийг 2000 оны төрийн гол айлчлалуудаар жишээлэн хөндөн бичсэн өгүүллийг дээрх номд бичсэний үргэлжлэл болгон дор сийрүүлэв.

**Нэг. Энэтхэг-АНУ-ын харилцаа, XXI зууны
түншлэл (Важпайн айлчлал, 2000 оны 9 дүгээр сар)**

1.1. Айлчлалын зорилго ба нөхцөлдүүлсэн хүчин зүйлс

1. БНЭУ-ын Ерөнхий сайд (Н.Рао) хамгийн сүүлд 1994 оны 5-р сард АНУ-д айлчилсан бөгөөд түүнээс хойш 6 жил өнгөрч, дээд хэмжээний уулзалтын давтамжийг хадгалах үүднээс Энэтхэгийн талаас зайлшгүй айлчлах шаардлага тулгарсан, нөгөөтэйгүүр 22 жил завсарласны эцэст БНЭУ-д айлчилсан АНУ-ын Төрийн анхны тэргүүн нь Б.Клинтон байсны

(2000 оны 3 дугаар сар) хувьд А.Б.Важпайн хариу айлчлал цаг хугацаа, протоколын хувьд зайлшгүй хийгдэх ёстой байв.

2. 1991 оноос хойш эдийн засгийн реформ хийж эхэлсэн БНЭУ-д АНУ-ын оруулсан хөрөнгө оруулалт 15 орчим тэрбум ам.долларт хүрч, энэ нь хоёр Засгийн газруудын тооцсон хэмжээнээс давж, цаашдаа огцом өсөх хандлагатай (2001 онд АНУ-ын хөрөнгө оруулалт 5 тэр бум ам.доллар болов) улмаар дараагийн 3 жилд энэ тоо нийтдээ 15 тэр бумд хүрэх төлөвтэй байгаа, эдийн засаг - худалдаа - бизнесийн хамтын ажиллагааны энэхүү огцом өсөлтийг хоёр Засгийн газар бүрэн хянаж чиглүүлэх, түүнийг төр засгийн дээд хэмжээнд хөхүүлэн дэмжиж буйгаа илэрхийлэх шаардлагаар Важпайн айлчлалын бас нэг нөхцөл бүрдсэн юм.

3. АНУ-д Ерөнхийлөгчийн сонгуулиар төр засгийн эрх солигдох мөч ойртож байсан тэр үед гол өрсөлдөгчид болох-А.Гор, Ж.(W) Буштай биесчлэн танилцаж, Энэтхэгийн уламжлалт, зарчмын байр суурийг тэдэнд нотлох нь ноён Важпайн айлчлалын нэг зорилго байв. АНУ-д төрийн эрхийг аль ч нам, хэн ч барилаа гэхэд нэгэнт эрчээ авсан хоёр талын хамтын ажиллагаа цаашид саатахгүй болж чадлаа гэж Ерөнхий сайд хожим дүгнэсэн нь үүний нотолгоо байв.

4. Өмнөд Азид Б.Клинтон айлчилснаас хойш 5 сар гаруйн хугацаа өнгөрсөн байсан тэр үед Кашмирийн байдал тогтворгүй хэвээр, хил дамнасан терроризмын аюул улам (Энэтхэг рүү) наашилж, дээрээс нь хар тамхины наймаа, зэвсгийн хууль бус арилжаа Энэтхэгээр дамжих болж (Зүүн Өмнөд Азиас Төв Ази руу, эргээд Төв Ази-Афган, Пакистанаас Энэтхэг рүү), бүс нутагт бүхэлдээ аюул нүүрлээд байлаа. Үүнийг АНУ-д таниулж мэдрүүлэх, лалын терроризмын эсрэг хамтарсан ажлын хэсгийн хэлбэрээр олон улсын нэгдсэн сүлжээ (эвсэл) бий болгох зорилгоо уялдуулах нь дээрх айлчлалын стратегийн нэн чухал зорилт байсан билээ.

Похранд 1998 оны хавар цөмийн туршилт хийснээс үүдэн Энэтхэгийн эсрэг зарласан олон улсын эдийн засгийн (НҮБ-ын АЗ-ийн) хориг бодит үр дүнгээ өгөөгүй, аяндаа суларч хүчгүй болсныг дэлхийн хамтын нийгэмлэгт нотлох, энэ үүднээс АНУ-ын хоригийг удаашруулалгүй ёс төртэй цуцлуулсныг зарлуулах нь БНЭУ-ын олон улсын нэр хүндэд хамгаас чухал байв. Энэ нь Важпайн айлчлалыг бас нөхцөлдүүлсэн юм. (Гэхдээ айлчлалын үеэр энэхүү хоригийг цуцалж өгөх хүсэлт Америкийн талд зориуд тавиагүй гэдгээ Ерөнхий сайд Делид эргэж очоод мэдэгдсэн).

Энэтхэг улс оюуны багтаамж бүхий үйлдвэрлэлээр (мэдээллийн технологи) дэлхийг гайхашруулах болж, "2 дахь жүүдүүд" хэмээн Энэтхэг цагаачид баруунд хочлогдож буй үед болж байгаагаараа Важпайн айлчлал нь улс төр эдийн засаг, бизнес-оюун санааны иж бүрэн хослол бүхий цоо шинэ маягийн айлчлал болох ёстой байлаа. Үүгээр Энэтхэг-АНУ-ын харилцаанд цоо шинэ эрин үе эхлэх, энэ харилцаа XXI зууны жинхэнэ холбоотны (Важпай өөрөө Natural Allies гэж нэрлэсэн) түншлэлийн эхэн болох ёстой гэж үзсэн бөгөөд айлчлалын зорилт ингэж тавигдсан юм. Үүнтэй нэгэн адилаар Өмнөд Ази руу чиглэсэн Америкийн бодлого шинэчлэгдэх ёстой гэж тэр үзжээ.

Олон улсын харилцаанд гарч буй шинэ хандлага (глобалчлал, бүсчлэл, нефтийн шинэ хямрал, дэлхийн төлөөх олон туйлт өрсөлдөөний бодлого), их гүрнүүдийн хүчний харьцааны өөрчлөлт, Азид АНУ-ын нөлөөг саармагжуулахын төлөөх хүчний шинэ хуваарилалт (ялангуяа Орос-Хятадын стратегийн түншлэл) зэрэгт Ардчилсан Энэтхэгийн нээлттэй, бие даасан гадаад бодлого чухал хүчин зүйл хэвээр байж, тэнцвэржүүлэх үүрэгтэй гэдгийг Энэтхэг-АНУ-ын харилцааны шинэ үе эхэлж байгаагаар ийнхүү давхар нотлох ёстой байв.

1.2. Айлчлалын явц ба үр дүн

Энэтхэгийн Засгийн газар, улс төрчид, төвийн гол гол хэвлэлүүд уг айлчлалын талаар Конгрессын хоёр танхимын хамтарсан хуралд Ерөнхий сайдын хэлсэн үг, хамтарсан албан мэдэгдэл, Энэтхэгийн эсрэг хоригийг цуцлах тухай АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын гаргасан тогтоол, Махатма Гандийн хөшөөний нээлт, Цагаан ордны хүлээн авалт, Энэтхэгийн цагаачдын болон Нью-Йоркод болсон Мянганы чуулганы үеийн уулзалтуудаас гадна Микрософтын ерөнхийлөгч Б.Гейтс Энэтхэгт айлчилсан айлчлал, түүнд үзүүлсэн хүндэтгэл, 6 тэрбум ам. долларын өртөг бүхий хэлэлцээрүүд хийгдсэн нь энэ айлчлал тавьсан зорилгодоо бүрэн хүрсэн төдийгүй цаашдын хамтын ажиллагааны бат бэх үндсийг тавьж өглөө гэж дүгнэсэн юм.

Кашмир дахь аллага хядлага, тогтворгүй байдлын талаар хоёр тал байр сууриа улам ойртуулсны сацуу АНУ-ын зүгээс Пакистаныг шахсаар байх болно гэдгээ дахин нотлов. Энэ үүднээс Хамтарсан ажлын хэсгийн үйл ажиллагааг цаашид байнгын болгож, зөвхөн терроризмын асуудлаар бус, НҮБ-ын Энхийг сахиулах, Афганы байдал, хар тамхины арилжааны (наркотерроризм) талаар байнгын санал солилцдог, бодлогоо уялдуулдаг институциональ механизм бий болгохоор тохиролцжээ.

Цөмийн туршилтыг бүрэн хориглох тухай гэрээний (СТВТ) талаар АНУ Энэтхэгээр буулт хийлгэж, гарын үсэг зуруулах баталгаа гаргуулж чадаагүй, тэргүүлэх гэсэн анхны зорилгоосоо ч ухарсан зэрэг нь Клинтонь айлчлалаар харагдаж байгаа бөгөөд энэ удаа ч АНУ түүнийг тэгтлээ шахсангүй нь Энэтхэгийн хувьд олон улсын нэр хүндийн том ялалт хэвээр үлджээ.

Эрчим хүч, банкны шинэчлэл, мэдээллийн (софтвеирын) технологийн салбарт АНУ-аас Энэтхэгт 6-7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр сайд нарын хэмжээнд гарын үсэг зурсан нь Важпайн айлчлалын бас нэг гол ололт байв. Түүнийг хэрэгжүүлэх хоёр улсын компаниуд болон банкнуудын хооронд хамтын ажиллагааны нэгдсэн сүлжээ бий болсноор Энэтхэгийн хүн ам шигүү суурьшсан 3 мужид аварга том цахилгаан станц барих төсөл, Ексим банкны зээл, бусад үйлчилгээний салбаруудын хамтын ажиллагаа санхүүжигдэх нөхцөл бий болохын сацуу мэдээллийн технологийн компаниуд хоорондын харилцаа (Микрософт-Насском, Микрософт-Тата, Микрософт-Випро, Микрософт-Сатьям зэрэг) бүрэн төлөвших аж.

Цаашлаад Дэлхийн оюуны өмчийн байгууллагын хүрээнд хоёр тал мэдээллийн технологийн ололтоо хамтран баталгаажуулах, хамгаалуулах чиглэлээр ажиллах, хоёр талын Вэбсайт руу чөлөөтэй нэвтэрдэг болох, улмаар мэдээллийн технологийн талаар дэлхийн хэмжээнд консенсус явуулах талаар ярилцав. Мөн Б.Гейтс, дэлхийд түүний дараа хөрөнгөөрөө орж буй Випро компанийн эзэн А.Премжи нар ХХI зуунд АНУ, Энэтхэг хоёр хэрхэн хамтран ажиллах стратегийг тохиролцсон юм.

1.3. Айлчлалын талаархи шүүмжлэл ба бухимдал

Ер нь Энэтхэгийн практикаас үзэхэд, аливаа томхон айлчлалын дараа түүний үр дүнг их сургууль, судалгааны хүрээлэнгүүд, гадаад харилцааны холбоод, найрамдлын нийгэмлэгүүд, намууд семинар болон бага хурлын хэлбэрээр шүүн хэлэлцдэг. Тэр дагуу Важпайн айлчлалын талаархи "хэлэлцүүлэг" өнөөдөр ч үргэлжилж байна. Энэ "хэлэлцүүлэг" дараагийн дээд хэмжээний уулзалт хүртэл үргэлжлэх төлөвтэй тул айлчлалын сайн мууг хөндлөнгийн бичээч би бээр шууд үнэлэн дүгнэх боломжгүй. Дели дэх дипломат корпусын хүрээнд санал солилцсон байдлаас ажвал, мөн эрх баригч БЖП намынхны зүгээс үнэлсэн үнэлгээ, ГХЯ-ны хэмжээнд айлчлалын үр дүнг өндөр үнэлсэн зэрэг нь айлчлалыг маш амжилттай хэрэгжүүллээ гэж дүгнэхээр байв.

Харин Энэтхэгийн улс төрийн намууд, улс төрчид, цаашлаад хүн бүрийн сэтгэлд тэр бүр нийцээгүй, тийм байх ч албагүй. Ялангуяа Конгресс намын зарим лидер (жишээ нь Гадаад хэргийн Төрийн сайд асан Натвар Сингх) айлчлалыг буулт хийсэн, америкжсан, хэт долдойлсон явдал боллоо гэж шүүмжиллээ. В.Гейтсийг Энэтхэгийн 15 мужийн Тэргүүн сайд болон танхимын 10 сайд хүлээн авч уулзсан болон түүнд Засгийн газраас хүндэтгэл үзүүлж хүлээн авалт хийснийг дэндүү ёс бус зүйл гэж тэрээр зүхээд, Энэтхэг улс хөгжиж буй орны удирдагчийн байр сууриа алдаж, АНУ-ын бодлогын нөлөөнд татагдах вий гэж болгоомжлуулсан юм.

Энэтхэгийг АНУ, Өрнөдийн орнууд, Израильтай илүү ойртуулах БЖП намын бодлого хэрэгжиж эхэллээ. Түүнийг Важпай ГХЯ-аараа дамжуулж хийсэнгүй. Харин ерөнхий сайдын Тамгын газрын дарга бөгөөд УАБЗ-ийн зөвлөх Б.Мишрагаар дамжуулан хийлээ гэхчлэн зарим улс төрчид шүүмжилжээ. АНУ-ын хэвлэлүүд Важпайд тун бага зай эзлүүлсэн нь цөмийн зэвсэгтэй, тэрбум хүн амтай Энэтхэгийн хувьд туйлын чамлалттай ба гутамшигтай. Ингэснээр Важпай хэнд үйлчилсэн хэрэг вэ гэсэн маргаан ч дэгдсэн юм. Энэтхэгийн гадаад бодлого 2000 оны турш АНУ, ОХУ, Хятад, Япон руу чиглээд, зайлшгүй анхаарах ёстой хөршүүдээ мартлаа хэмээн гурав дахь ертөнцийн талын улс төрчид гомдолложээ. Ухаан нь Шри Ланка, Бангладеш, Балбыг нэгэн зэрэг авч үзэх ёстой юм байх. Дээрх хугацаанд АНУ, ОХУ-ын ерөнхийлөгч нар, Японы Ерөнхий сайд Энэтхэгт, Энэтхэгийн Ерөнхийлөгч БНХАУ-д, Ерөнхий сайд АНУ-д айлчилсан дипломатын ачаалалтай зурвас үе юм.

эрхт б
болгол
асууда
Муша
ын Аю
хүлээс
үргэлж
хийгдс
Важпа
мөч ту
юугаа

зориул
маргаа
дэвши
ханди
бизнес
уригдс
байсан
А.Гор
тоогоо

гутаах
дээрх
ажигл
хонзо
болов
болой

2.1 Ха

хориг
түүнд
нь тү
нь Хя
нэмсэ
ч хүй
Хуул
хүйтр
шуган

Хэтэрхий үнэ өртөгтэй зээл, хөрөнгө оруулалт нь Энэтхэгийн бүрэн эрхт байдлыг алдагдуулж, АНУ-ын эрх ашигт үйлчилж, түүний хараат болголоо гэж зүүний болон коммунист намууд шүүмжилдэг. Кашмирын асуудал дээр АНУ-аар буулт хийлгэж, Пакистаныг болон генерал Мушараффыг яллуулж "Террорист улс" хэмээн зарлуулж чадсангүй, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүнд элсэх талаар АНУ-аас дэмжлэг хүлээсэнгүй гэж тэд Ерөнхий сайдаа хараар будав. Кашмирт аллага үргэлжилсээр, хүмүүс амь насаа алдсаар байтал энэ талаар ямар ч алхам хийгдсэнгүй, энх тайвныг тогтоох баталгаа байхгүй хэвээр байна, ер нь Важпай цаг үеэ зөв олж айлчилсангүй, тэртээ тэргүй засаг төр солигдох мөч тулсан үед, хариуцлага хүлээхгүйгээр мөдхөн зайлж одох Клинтонтой юугаа ч шийдэх билээ гэх жишээтэй шүүмжилж байв.

Тэр үеийн Ерөнхийлөгч Клинтон Цагаан ордондоо Важпайд зориулж хүлээн авалт хийсэн үү? Эсвэл хандив цуглуулав уу? гэсэн ноцтой маргаан өнөөг хүртэл Энэтхэгийг шуугиулсаар АНУ-ын Сенатад нэр дэвшин өрсөлдсөн хатагтай Х.Клинтонь сонгуулийн өмнөх компанид хандив болгон дээрх хүлээн авалтын үеэр энэтхэг гаралтай Америкийн бизнесийн хүрээнийхэн олон арван мянгаар нь доллар өгсөн гэнэ. Зоогт уригдсан 646 зочны дор хаяж 100 нь хандивын чект гарын үсэг зурж байсан нь илэрчээ. Цаашлаад Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн А.Гор, Ж.Буш нарт энэтхэг цагаачаас цуглуулж өгсөн мөнгөн хандив тоогоо алдсан гэхчлэн шүүмжилснийг энд жагсааж барахгүй.

БЖП тэргүүтэй барууны чиглэлийн Засгийн газрыг шившиглэх, гутаах, шүүмжлэх, яриа цуурхал дэгдээх нь энүүхэнд бөгөөд түүнд нь дээрх удирдагчид тэгтлээ ундууцах буюу эргүүлж зөвтгөх байдал ажиглагддаггүй. Дүгнэвээс, хуучинсаг коммунист, үеэ өнгөрөөсөн, хонзогносон дайралтууд гадаад дотоод бүх бодлого дээр ширүүссээр байх боловч БНЭУ-ын зарчмын байр сууринд нөлөөлсөн нь огтхон ч үгүй болой.

Хоёр. Энэтхэг-Хятадын харилцаа:Шинэ хандлага, шинэ ирээдүй

2.1 Харилцааны идэвхжил

БНЭУ 1998 онд цөмийн туршилт хийснээс үүдэн Энэтхэгийн эсрэг хориг тавих тухай НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол батлагдаж, түүнд БНХАУ нэгдэн орсноор сайжирч эхэлж байсан хоёр талын харилцаа нь түр саатсан билээ. Үүнтэй давхцан БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд нь Хятадыг "нэгдүгээр зэргийн дайсан" хэмээн ил зарлаж, цэргийн төсөв нэмсэн болон цөмийн туршилт хийснээ үүгээр зөвтгөсөн нь харилцааг бүр ч хүйтрүүлсэн юм. Үүн дээр Тайваныг хүлээн зөвшөөрөхийг БНЭУ-ын Хууль зүйн сайд уриалан дуудаж бөөн хэрүүл үүсгэсэн байв. Энэ хүйтрэлийг арилгах үүднээс Энэтхэгийн тал эхлэн буулт хийж, ГХЯ-дын шугамаар явагддаг хамтарсан хорооны хурлыг (улс төрийн зөвлөлдөөн)

сэргээж нутаг дэвсгэрийн маргаанаа шийдэхэд бэлэн байгаагаа илтгэснээр харилцаа эргэж сайжирч эхлэв.

Хэрэв Энэтхэгийн тал Сикким мужийг Хятадын төвтэй холбосон худалдааны гол зам нээхийг зөвшөөрвөл, хариуд нь Хятадын тал Сиккимийг БНЭУ-ын нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрч болох талтайг аль аль нь үгүйсгэхгүй байна. Энэ маргаан 2000 онд огт яригдсангүйгээр үл барам харилцаанд шинэ асуудлууд дэвшигдэн тавигдаж, хоёр талын харилцааны агуулга огт өөрөөр тэлжээ.

2000 оны байдлаар, БНЭУ-ын Ерөнхийлөгч, Гадаад хэргийн сайд, Худалдаа аж үйлдвэрийн сайд, Мэдээллийн технологийн сайд Хятадад цувран айлчилж, хариуд нь БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Тан Зясюань Энэтхэгт ирэв. 2001 он гарсаар БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Пэн, ирээдүйн Ерөнхий сайд гэгдэж буй намын 3 дахь лидер Ли Чанчун нар БНЭУ-д айлчлав. Мөн хоёр тал АСЕАН-ы Бүсийн чуулга уулзалтын хүрээнд яриа хэлэлцээгээ үргэлжлүүлж, олон улсын ба бүс нутгийн тулгамдсан асуудлаар зөвлөлддөг механизмыг эхлүүлэв.

2.2 Олон улсын ба геополитикийн асуудлууд

Энэтхэг, Хятад хоёр хоёул АРФ-ийн түнш гишүүн орнууд бөгөөд Ази-Номхон далайн бүс нутагт энх тайвныг сахиулах, тогтвортой байдлыг хадгалах сонирхолтой, мөн хар тамхины зөөвөр, хил дамнасан (магадгүй лалын) терроризмоос сэргийлэхийн тулд харилцаа, хамтын ажиллагаагаа уялдуулах зайлшгүй шаардлагатай гэж хоёр Гадаад хэргийн сайд Делид уулзахдаа хүлээн зөвшөөрчээ. Хятад нь Төв Ази, Каспи, Персийн булангийн эрчим хүчний эх ундарга нөөцийг сонирхож эхэлж байгаа бол Энэтхэг мөн тийшээ сонирхолтой, Төв Азийн эрчим хүчний (жишээ нь Киргиз) сүлжээтэй холбогдож эхэлсэн. Аль аль нь Оростой цэрэг-стратегийн түншийн харилцаатай бөгөөд ОХУ нь пуужингийн довтолгооноос хамгаалах системийн талаархи АНУ-ын хөтөлбөрийн эсрэг холбоотноороо хоёуланг татан оруулах гэж дипломатын шахалт үзүүлж буй.

НАТО-гийн хүчин Югославт халдсанаас үүдэн АНУ-ын талаархи үзэл бодлоо ойртуулж эхэлсэн төдийгүй "Америкийн империализмын эсрэг" ЭКН, ЭКН(М) бусад зүүний хүчний эсэргүүцлийн хөдөлгөөн зарим талаар нэгдсэн ойлголтод хүрч болзошгүй гэдгийг хэвлэлүүд, улс төрчид, Хятадын зарим дипломатч ярих болсон нь дараа дараагийн алхмуудаар нотлогдсон.

2.3 Харилцааны шинэ салбар

Өнөөг хүртэл Энэтхэг-Хятадын харилцааны тухай ойлголтод "газар нутгийн маргаан", "хилийн дайны" үүх түүхийг голлож ирсэн бол эдүгээ уг асуудлыг хоёр тал орхиж, эдийн засаг-мэдээллийн технологийн хамтын ажиллагааны алхмуудыг угсруулан хийж эхлэв. Энэ салбарт хоёр орны сонирхол хосолж нийцжээ. Өөрөөр хэлбэл Хятадын эрэлт хэрэгцээ,

Энэтхэгийн ханган нийлүүлэлт борлуулалт хоёр талаасаа холбогдож буйг дараахи баримтаас тодруулья.

БНХАУ-д интернет хэрэглэгчдийн хүрээ огцом тэлжээ. 1993 онд тус оронд интернет хэрэглэгч ердөө 17000 байсан бол 1999 онд 9 сая болж огцом өссөн байна. Энэ оронд персональ компьютерийн тоо жилд 30 хувиар өсч дэлхийн дундаж үзүүлэлтээс 2 дахин давжээ. 2000 онд Хятадын мэдээллийн технологийн аж үйлдвэр 20 хувиар өсч, энэ өсөлт 2001 оноос 25 хувь хүрч, ойрын 5 жилдээ уг үзүүлэлтээс буухгүй байх аж.

Гэтэл Энэтхэгийн софтвейрын үйлдвэрлэл жилдээ 50 хувийн өсөлттэй, мэдээллийн технологийн экспорт нь үндэсний нийт экспортынхоо 35 хувийг бүрдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн 7,5 хувийг эзэлж байна.

БНХАУ нь Бээжин хотын Хайдань дүүрэг, Шанхайн Пудон дүүргийг мэдээллийн технологийн гол төвөө хэмээн зарлаж, тийш нь хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бол Энэтхэг нь Бангалор, Хайдарабад хоёр хотыг "cyber"-кибернетикийн төв болгох зорилтыг шийдэж байна.

БНЭУ-ын Мэдээллийн технологийн сайд П.Махажан 2000 оны 7-р сарын сүүлээр БНХАУ-д айлчилж, Хятадын Мэдээллийн технологийн сайд У Жичуаньтай хэлэлцээ хийсний дүнд хоёр орны худалдаа (жилдээ 2 тэрбум ам. доллар байгаа) дахь софтвейрын нийлэлтийн хэмжээг (гарын үсэг зурсан харилцан ойлголцох санамж бичгээс үзвэл, инфотех салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэх, хамтарсан үйлдвэрүүдийн тоо нэмэгдэх, ингэснээр мэдээллийн технологийн түншлэл хөгжих төлөвтэй) огцом нэмэгдүүлэх, улмаар харилцан зорчих визийг хөнгөвчлөх талаар ярилцан тогтжээ. Айлчлал дуусмагц мэргэжилтнүүд нь хоёр талаасаа хөвөрч, хамтарсан үйлдвэрүүд нь Хятадад хурын дараахи мөөг мэт олширч, Энэтхэгийн хэд хэдэн компани зах зээл рүү нь гүн нэвтэрчээ.

2.4 Цаашдын төлөв

БНЭУ-ын мэдээллийн технологийн гэнэтийн өсөлт Хятадтай тогтоосон харилцаагаар хязгаарлагдах ёсгүй гэдгийг ч Энэтхэгийн тал Махажаны айлчлалын үеэр нотолжээ. Тэр үеэр АРФ-ын гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалтад оролцсон БНЭУ-ын сайд Ж.Сингх АСЕАН-ы гишүүн орнуудад софтвейрын түрэлт (интервенци) хийнэ гэдгээ зарласан юм. АСЕАН-ы хөгжингүй орнууд Энэтхэгт хөрөнгө оруулалт хийсний хариуд Энэтхэг улс мэдээллийн технологийн ололт амжилтаа тэдэнтэй хуваалцаж, софтвейрын экспортоо нэмэгдүүлэх ажээ. 2000 оны 9-р сард АСЕАН-ы орнуудын эрдэмтдийн баг Делид ирж, энэ асуудлаар зөвлөлдсөн нь дараагийн алхам байлаа.

Үүний сацуу Энэтхэгийн Инфосайс, Аптех, Мэдээллийн технологийн институт, Випро зэрэг томхон компани корпорациуд бие даан зүүн Өмнөд Ази, Хятадын зах зээл дээр гарах боломжоор бүрэн хангагдлаа. Хятадын үндэсний компьютер софтвейрын хүрээлэн, Бээжингийн телекоммуникацийн захиргаа зэрэг улсын томхон компаниуд

Энэтхэгийн гол түнш болохоор хэлэлцэн тохирч, үйл ажиллагааны чиглэлээ Өмнөд Ази руу хандуулжээ.

2.5 Дүгнэвээс

Дэлхийн хүн амын 40 гаруй хувийг бүрдүүлдэг Азийн хоёр том орон харилцааны өнгөрсөн үеийн зөрчлийг аажмаар саармагжуулан орхигдуулж, хамтын ажиллагааны шинэ гараа эхлүүлснийг 2000-2001 оны тэр үйл явдлууд ийнхүү илтгэн харуулж байна. Хятадын нийт гадаад худалдааны жилийн эргэлт 300 тэр бум ам.доллар бөгөөд Энэтхэгтэй хийх софтвер, инфотех-ийн солилцоо, экспорт импорт 2001 оноос огцом өссөнөөр дээрх тоон үзүүлэлтэд чанарын өөрчлөлт гарч, эзлэх жин нь дагаж өслөө.

Ингэснээр Энэтхэг-Хятадын харилцаанд учир битүүлэг шинэ төлөв бий болох магадлалтай. Үүнийг шинэ түншлэлийн эх гэж дүгнэж болох юм. Зах зээлийн багтаамж, хэрэглээ хэрэглэгчийн хүрээ, газар нутгийн ойр дөт (хил залгаа) зэрэг хүчин зүйлээр авч үзвэл, Азийн хоёр том гүрний хооронд өвөрмөц харилцаа төлөвшиж эхлэв.

Хятадаар дамжин Энэтхэгийн "инфотех интервенци" Зүүн Ази, Сибирь, Алс Дорнод руу тэлэх тухайд ч энэтхэгүүд ярьсаар буй. Ийм нөхцөлд манай Монгол орон энэ үйл явцын гадна үлдэх ёсгүй бөгөөд түүнд эртнээс бэлтгэх хэрэгтэй. Энэ бэлтгэл нь Монгол-Энэтхэгийн хооронд мэдээллийн технологийн хамтын ажиллагааг эхлүүлэх, Энэтхэгийн экспертиз, технологийг түншлэн мэдээлэл-харилцааны шинэ орон зайг бүс нутагтаа бий болгоход чиглэгдэх ёстой болов уу. Монгол-Хятадын харилцаанд Энэтхэгийн оролцоог давхар харгалзах, Хятадын мэдээллийн технологийн идэвхжил, хөрөнгө оруулалт, хөрөнгийн урсгалыг худалдаа-эдийн засгийн харилцаанд тусгах, Сибирь, Алс Дорнод руу софтверын экспорт хийх гүүр нь болох хэтийн зорилгыг судалж үзэх нь зүйтэй биз ээ. Үүний анхны алхам болгож, 2001 оны 9-р сард БНЭУ-ын мэдээллийн технологийн сайд П.Махажаныг эх орондоо айлчлуулж, 1 сая ам.долларын өртөг бүхий мэдээллийн технологийн төв Улаанбаатарт байгуулахад тохиролцсон нь томхон дэвшил билээ.

Гурав. Орос-Энэтхэгийн стратегийн түншлэлд В.Путины айлчлал

3.1 Айлчлалын зорилго, нөхцөл

ОХУ-ын төрийн Тэргүүн Энэтхэгт айлчлах тухай асуудал 3-4 жилийн өмнөөс зарлагдаад Б.Ельциний биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан цуцлагдаж хойшилсоор оронд нь Ерөнхий сайд Е.Примаков 1998 оны сүүлчээр айлчилсан билээ. Гэтэл түүнээс хойш ОХУ-д парламентын сонгууль явагдаж, дараа нь Ерөнхийлөгч солигдож, шинэ Энэтхэгийн гадаад бодлого 2000 он гарсаар АНУ, Ойрхи Дорнод, Хятад,

Япон, АСЕАН руу голлон чиглэгдэж, гадаад бодлогын аль эргүүлэгт ОХУ-тай харилцах бодлого яваа нь мэдэгдэхгүй болсон байв.

Ер нь "Хүйтэн дайнаас" хойшхи олон улсын шинэ нөхцөл байдалд Орос-Энэтхэгийн харилцааг шинээр томъёолох, ХХI зуун руу чиглүүлсэн харилцааны цоо шинэ үеийг эхлүүлэх шаардлага зүй ёсоор тулгарсан юм. 1991 онд 5,5 тэр бум ам.доллар эргэлдэж байсан худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-технологийн нөөц боомжийг нээн илрүүлэх нь өнөөгийн тулгамдсан зорилт болжээ.

Энэтхэгт ОХУ-ынхтай яг адил (Кавказын бүс нутаг, ялангуяа Чечень, мөн Тажикстан,) лалын терроризмын аюул бодитой оршиж, сепаратизм, терроризмын эсрэг хамтран тэмцэх зайлшгүй шаардлага тулгарсан. Филиппиний лалын босогчид гадаадын жуулчдыг 5 сар хэртэй барьцаалсан, Чеченд дайны явц нуугдмал байдалд шилжсэн, Тажикстанд байдал тогтворжоогүй, Киргиз, Узбекийн хил түгшүүртэй буй, Кашмирт лалынхан болон Энэтхэгийн Засгийн газрын хооронд гал зогсоосон боловч үр дүнгүй зэрэг 2000 оны турш дэлхий дахиныг айлгаж цочоосон бүхэн Орос-Энэтхэгийн дээд хэмжээний уулзалтын нэг гол сэдэв болон хуримтлагдсан байв.

Нөгөө талаас Хятадтай яг эн тэнцүү зэвсэглэх ёстой гэсэн Энэтхэгийн стратегийн зорилт Орос-Энэтхэгийн харилцааг идэвхжүүлэх, тэр нь худалдаа, цэрэг-техникийн хамтын ажиллагаагаар хэрэгжих нэг нөхцөл байв. АНУ-ын пуужингийн довтолгооноос хамгаалах хөтөлбөрийг эсэргүүцэх стратегийн түншлэлдээ Энэтхэгийг татан оруулах сонирхол Оросын хувьд ч давамгайлав. Е.Примаковын айлчлалын үеэр нэгэнт эхлүүлчихсэн стратегийн түншлэлийг гэрээ хэлэлцээрээр баталгаажуулж, олон талт хамтын ажиллагаагаа институциональ механизмд оруулах явдал шаардлагатай нь хаа хаанаа харагджээ.

Мэдээллийн технологийн гайхамшигт хувьсгал хийж, зөвхөн софтверийн үйлдвэрлэл нь жилдээ 50 хувиар өсч буй Энэтхэгтэй технологийн салбарт түншлэх сонирхлоо АНУ, Япон, Европын холбоо, улмаар Хятад, Зүүн Ази, Австрали илэрхийлж, хэдэн тэр бумаар хөрөнгө оруулалт Энэтхэг рүү оруулж эхэлсний ард Орос ганцаараа үлдэж хоцрохыг хүсэхгүй. Үүнийгээ ч цаг алдалгүй эхлүүлэхийг яаравчлав.

Орос, Энэтхэг хоёр хоёул олон туйлт дэлхийн төлөө байна, тийм дэлхий үүслээ гэж тус тусдаа мэдэгдэх авч хамтарсан тунхаглал, баримт бичгээр нотлоогүй өдий хүрснийг өөрчлөн өнөөгийн болон ирээдүйн олон улсын харилцааг хамтарч томъёолох шаардлагатай гэж үзэж байлаа.

Энэ бүх асуудлыг нэг дор, урт хугацааны хөтөлбэртэйгээр (2010 он хүртэл) шийдэх нь 2000 оны 10 сард В.Путины БНЭУ-д хийсэн айлчлалын гол зорилго байлаа. Энэхүү айлчлал нь 2000 онд Энэтхэгээс дэлхийн их гүрнүүдтэй харилцсан, хэрэгжүүлсэн угсраа саммитын тэр оны сүүлчийн оргил нь болсон юм (Б.Клинтон, Ё.Мори, В.Путин БНЭУ-д, Энэтхэгийн Ерөнхийлөгч Франц, Хятадад, Ерөнхий сайд АНУ-д гэх мэт).

3.2 Айлчлалын явц, үр дүн

ОХУ-ын Ерөнхийлөгчийн тэрхүү айлчлалаар нийт 24 баримт бичигт гарын үсэг зурсны 11 нь улс төр, эдийн засгийн харилцааны, цэрэг-техникийн, шинжлэх ухаан-технологийн үндсийг тодорхойлсон хэлэлцээрүүд, 11 нь салбарын хамтын ажиллагааны (хөдөө аж ахуй, харилцаа холбоо, хууль зүй-компанийн хэрэг эрхлэх, ашигт малтмал, металлург, эрчим хүч гэх мэт) протокол, үлдэх 2 нь нефть, байгалийн хийн чиглэлийн хамтын ажиллагааны МоU байна.

Дээрх хэлэлцээрүүдээр тухайн салбарын хамтын ажиллагааг хариуцах Засгийн газар хоорондын комиссууд байгуулагдаж, салбарлан тусдаа хэлэлцээ хийж зарим асуудлыг шийджээ. Тухайлбал, цэрэг-техникийн хамтын ажиллагааны комисс хоёр орны харилцаанд байтугай дэлхийн улс орнуудын түүхэнд тэр бүр байдаггүй томхон хэлцлийг эцэслэжээ. ОХУ-аас Энэтхэгийн армийн зэвсэглэлд нэвтрүүлэх орчин үеийн Т-90 супер танк 310-ыг (705 сая доллараар арилжах) бэлнээр (124 нь) буюу Энэтхэгт угсрахаар (186 нь) нийлүүлэх, Сухой-30 байлдааны нисэх онгоц 140-ийг Энэтхэгт угсрахаар технологийг нь шилжүүлэх, стратегийн бөмбөгдөгч Ту-22 Бейкфайер нисэх онгоц 4-ийг Энэтхэгийн агаарын цэргийн хүчинд өгөх, Оросын тэнгисийн цэргийн зэвсэглэлээс хасагдаж буй "Адмирал Горшков" нисэх онгоц тээгч (Миг-29 онгоц 46-г ачсан) хөлгийг Энэтхэгт нийлүүлэхээр тогтсон нь айлчлалын болон яриа хэлэлцээний ноён оргил болжээ.

Эдгээрийн арилжааны нийт өртөг 3 тэр бум ам.доллар бөгөөд зэвсэглэлд бүрэн нэвтрүүлсний дараа сэлбэг эд анги, үйлчилгээний зардлыг оруулбал нийт 5-7 тэр бум ам.доллар Энэтхэгээс Орост эргэж төлөгдөх ажээ. Ингэснээр ОХУ-ын улсын төсөв ч зузаарч буй хэрэг.

Ерөнхийлөгч В.Путин, Ерөнхий сайд А.Б.Важпай нарын гарын үсэг зурсан Стратегийн түншлэлийн тухай Тунхаглал нь түүхнээ үеэ өнгөрөөсөн Үл довтлох ба Төвийг сахих гэрээтэй зарим талаар адил юм шиг ч сэтгэгдэл төрөхүйц баримт бичиг юм. Түүнд цэрэг-улс төрийн холбоо байгуулахыг зориогүй хэмээн 2 тал зориуд цохон тэмдэглэсэн. Гэхдээ XXI зуунд дэлхий дахинд шинэ нөхцөл байдал үүссэн тул түүнд зохицсон, уламжлалт биш, эрх зүйн үндэслэл болохуйц акт хэрэгтэй болсон нь илт байна. Уг тунхаглалаар улс төр, худалдаа ба эдийн засаг, батлан хамгаалах, шинжлэх ухаан ба технологи, соёл, бусад гэсэн 6 салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх заалтууд тусгагджээ. Бусад салбар гэдэгт тамхины хууль бус зөөврийн эсрэг хамтран тэмцэх тухай заалтууд, мөн эрүүгийн ба иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хамтын ажиллагааны асуудлууд хамтдаа тусгагдсан нь хоёр орон нийтлэг бэрхшээлтэй, түүнийг шийдэх нийтлэг аргатай гэдгийн илэрхийлэл болжээ.

Энэхүү заалтаас үндэслэн айлчлалын явцад Афганистаны талаархи хамтарсан ажлын хэсэг байгуулжээ. "Москва-Дели-Исламабад-Кабул-Москва" гэсэн тэнхлэгээр Пан-Исламын терроризмтэй явуулах хамтарсан тэмцэл ийнхүү эхэлж байна. (Гэхдээ Пан-Ислам, лалын терроризмтэй

тэмцэх гэдэг нэр томъёонд лалын шашинт ардчилсан улсууд эмзэг хандсаар буй) "Орост Чечень, Энэтхэгт Кашмир" гэсэн адил асуудал оршиж байна гэдгийг харилцан зөвшөөрснийг В.Путин Энэтхэгийн парламентад үг хэлэхдээ давтан мэдэгджээ. Ингэснээр Кашмираас-Чеченийг хүртэлх геополитикийн орон зайд хамтарсан тэмцлийн өргөн фронт, нэг үгээр геостратегийн урт хугацааны сонирхлын хослол үүсч байгаа хэрэг юм. Үүнийг ч тэд ийнхүү шууд ойлгуулсан юм.

3.3 Дүгнэвээс

1. ОХУ-ын шинэ Ерөнхийлөгч БНЭУ-тай харилцах бодлогыг шууд өөрийн мэдэлд авч, стратегийн гол чухал түншээ хэмээн үзэх боллоо. Ельциний үед харилцааг орхигдуулж сул орон зай гарсныг засч залруулж эхэлжээ. Үүнийг нотлох зорилгоор айлчлалыг гэнэт зарлаж, Путин өөрөө биечлэн Делид ирсэн нь тэр байв. Энэ нь найрсаг сэтгэлийн илэрхийлэл байлаа.

2. "Орос-Хятад-Энэтхэгийн стратегийн гурвалжингийн" тухай Е.Примаковын үзэл бодлыг хэрэгжүүлэх эхлэл тийнхүү тавигджээ. 2000 оны 7-р сард БНХАУ-д Путины хийсэн айлчлалын үеэр ОХУ-БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан бол ийнхүү Энэтхэгтэй мөн төрлийн тунхаглалд гарын үсэг зуржээ. Хэрэв Хятад, Энэтхэг хоёр ийм хэлэлцээр байгуулбал Азийн "эх цээжинд" цөмийн зэвсэг бүхий дэлхийн 3 том гүрний гурвалсан түншлэл үүсэх нь тэр болох биз ээ.

3. БНЭУ-ын хэт их зэвсэглэл дэлхий дахины анхаарал татаж, зарим талаар бусад улс гүрнийг эмзэглүүлэх хэмжээнд хүрэх болсон нь нотлогдов. Тус улс цөмийн зэвсэг туршсан, одоо цөмийн бөмбөг пуужин тээгч стратегийн хүнд бөмбөгдөгч нисэх онгоцтой боллоо. Ту-22 гэгч нь Америкийн стратегийн бөмбөгдөгч В-52 онгоцтой хүч тэнцүү онгоц бөгөөд ОХУ-аас өөр орны зэвсэглэлд байхгүй. Мөн XXI зууны супер танк 310-ыг авч буй нь үүрэг, зориулалт, хэрэгцээ талаасаа үл ойлгогдож байна. Өмнө нь 1979 онд ЗХУ-аас авсан Т-72 болон өөрийн хийцийн "Аржун" танк хэдэн арван мянгаараа зэвсэглэлд нь бас бий.

4. Хятад, Пакистаны зэвсэглэлд ямар зэвсэг байна, тэр бүхнийг өөртөө байлгаж, хүчний баланс барина гэж БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд нь яг тэр үеэр мэдэгдсэн юм. Чухамдаа Пакистан нь 1996 оноос эхлэн Украинаас Т-80 танк 300-г худалдан авч зэвсэглэлдээ оруулан Энэтхэгийн хилийн ойролцоо байрлуулсан нь ингэж дүгнэснийг зөвтгөх үндэслэл болж байна. Танкны үйлдвэрлэлийн салбарт Хятад, Британи, Франц, Украин улс Пакистантай хамтран ажилласанд энд гол баримт болгож байгаа хэрэг. Тиймдээ ч цэргийн зардлыг 2000 оны санхүүгийн жилд 28 хувиар нэмснээс үүдэн улсын төсвийн 20 гаруй хувийг эзлүүлжээ.

5. Орос-Хятад-Энэтхэгийн хоорондын гурвалсан харилцаа нь хэтдээ тус бүс нутгаас АНУ-ын нөлөөллийг шахах алхам болохыг үгүйсгэхгүй. Олон туйлт дэлхийн тухай гурвуул нэгдсэн ойлголтод хүрч чадлаа хэмээн

Хятадын "China Daily", "Жэньминь Жибао" сонинд тэр үед тэмдэглэснийг Энэтхэгийн хэвлэлд иш татжээ.

6. АНУ-тай харилцаагаа эрс сайжруулж тэдний холбоотон болж, улмаар Пакистаны байр суурийг орлох гэсэн Энэтхэгийн БЖП намын Засгийн газрын бодлоготой Орос-Энэтхэгийн түншлэл нь хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна. Энэтхэгийн талаар явуулж буй АНУ-ын бодлогыг авч үзвэл, В.Путины айлчлал, яриа хэлэлцээ, тохиролцоо нь зарим нэгэн болгоомжлолыг АНУ болон холбоотнуудад төрүүлж болзошгүй.

Article provides detailed and realistic pictures of Indian American relations in 20th century, prerequisites and follow ups of PM Vajpayee's visit, also new trends of Sino-Indian relations as well as strategic partnership of Russia and India in the light of president Putin's visit.